*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт*

| Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/ | |
|---|---|
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| | |
| *Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/* | *2025 оны 1 дүгээр сарын 01- ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр* |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Бэрх-Уул ХК; улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 1810002001; регистрийн дугаар: 2643928; үнэт цаасны код: BUE; утас: 99052064 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж ХК |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Уул уурхай: алт, жонш, чулуун нүүрс олборлолт; өрөмдлөг, халуун ус, худалдаа, үйлчилгээ |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | Ай Жэй Эй Эйч-Аудит ХХК. Хараат бус аудиторын тайлангийн огноо: 2026 оны 04 дүгээр сарын 27 |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 19'062'080 |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Бэлтгэсэн: Ж.Пүрэвдорж, ерөнхий нягтлан бодогч<br>Хянасан: А.Даваажав, гүйцэтгэх захирал |
| | |
| *1.* | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* |
| | Санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөг): эргэлтийн хөрөнгө 1,109,274.7; эргэлтийн бус хөрөнгө 6,337,456.7; нийт хөрөнгө 7,446,731.4; богино хугацаат өр төлбөр 28,561,796.5; урт хугацаат өр төлбөр 8,228,943.3; нийт өр төлбөр 36,790,739.8; эздийн өмч (29,344,008.4). |

| | | |
|---|---|---|
| | *Орлогын тайлан* | Орлогын тайлан (мянган төгрөг): борлуулалтын орлого 1,769,056.3; борлуулсан бүтээгдэхүүний өртөг 991,793.5; нийт ашиг 777,262.8; татварын өмнөх алдагдал (988,543.4); орлогын татварын зардал 10,014.2; тайлант үеийн цэвэр алдагдал (998,557.6). |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | Өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг): 2024.12.31-ний нийт өмч (28,345,450.8); тайлант үеийн алдагдал (998,557.6); 2025.12.31-ний нийт өмч (29,344,008.4). Хувьцаат капитал 1,906,208.0; хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 1,990,685.2; хуримтлагдсан алдагдал (33,240,901.6). |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | Мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг): үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (223,726.42); хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (26,901.76); санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 262,506.77; бүх цэвэр мөнгөн гүйлгээ 11,878.59; мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 37,157.04. |
| | | |
| *1.1.* | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | |
| | Ай Жэй Эй Эйч-Аудит ХХК 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зөрчилгүй дүгнэлт гаргасан. Аудиторын дүгнэлтээр 2025 оны санхүүгийн тайлан бүх материаллаг зүйлсийн хувьд СТОУС-ын дагуу үнэн зөв толилуулагдсан. | |
| *1.2.* | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* | |
| | Аудитын тайланд тусдаа тодорхойлох захидал хавсаргагдаагүй. Аудитын явцад удирдлагад мэдээлэх материаллаг гол асуудал тусгайлан тодорхойлоогүй. | |
| *2.* | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| *2.1.* | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | 2025 онд борлуулалтын орлого 1,769,056.3 мянган төгрөг, нийт ашиг 777,262.8 мянган төгрөг, цэвэр алдагдал 998,557.6 мянган төгрөг байв. Цэвэр ашгийн ахиуц түвшин -56.45%, хөрөнгийн өгөөж (жилийн эцсийн хөрөнгөөр) -13.41% байна. |
| *2.2.* | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | Эргэлтийн хөрөнгө 1,109,274.7 мянган төгрөг, богино хугацаат өр төлбөр 28,561,796.5 мянган төгрөг; эргэлтийн харьцаа 0.039. Мөнгөн хөрөнгө 37,157.0 мянган төгрөг. Нийт өр төлбөр 36,790,739.8 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 494.1%-тай тэнцэж, өөрийн хөрөнгө (29,344,008.4) мянган төгрөгийн хасах үлдэгдэлтэй байна. |
| *2.3.* | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | Тайлант хугацааны гадаад, дотоод орчны нөлөөлөл, салбарын зах зээлд эзлэх хувь болон бүтээгдэхүүн, үйлчилгээний өөрчлөлтийн талаарх нэмэлт мэдээлэл ирүүлээгүй. |
| *2.4.* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | Санхүүгийн тайлангийн гадуурх ажил, гүйлгээний талаар тусгай мэдээлэл ирүүлээгүй. Санхүүгийн тайланг СТОУС болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэл, тайлагналын шаардлагын дагуу бэлтгэсэн. |

| | | |
|---|---|---|
| 2.5. | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | 2025 оны эцэст богино хугацаат зээл 687,557.5 мянган төгрөг, урт хугацаат зээл 3,274,926.6 мянган төгрөг байна. Тайлант онд зээл, өрийн үнэт цаасны төлбөрт 333,207.82 мянган төгрөг төлсөн. Барьцаа, баталгааны дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлээгүй. |
| 3. | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | Байхгүй | |
| 4. | *Цалин урамшууллын мэдээлэл* | |
| | Тайлант хугацааны цалин, урамшууллын дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлээгүй. Мөнгөн гүйлгээний тайланд ажилчдад төлсөн дүн 368,189.19 мянган төгрөгөөр тусгагдсан. | |
| 5. | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | |
| | Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал А.Даваажав удирдсан. 2025 оны тайлант хугацааны ТУЗ-ийн бүрэлдэхүүн, хороо, хуралдаан болон засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлээгүй. | |
| 6. | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* | |
| | Гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал 31,626.55 мянган төгрөгөөр бүртгэгдсэн. Хөрвөх чадвар сул, өр төлбөр нийт хөрөнгөөс давсан бөгөөд өөрийн хөрөнгө хасах үлдэгдэлтэй байгаа нь санхүүжилт, төлбөрийн чадварын эрсдэл өндөр байгааг харуулж байна. | |
| 7. | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* | |
| | 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн нэр, эзэмшлийн хувь болон нийт хувьцаа эзэмшигчдийн тооны мэдээлэл ирүүлээгүй. | |
| 8. | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* | |
| | Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон шинээр хувьцаа гаргасан эсэх, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлэл ирүүлээгүй. | |

| | |
|---|---|
| 9. | *Ногдол ашгийн мэдээлэл* |
| | 2025 онд 998,557.6 мянган төгрөгийн цэвэр алдагдалтай ажилласан. 2025 оны ашгаас ногдол ашиг хуваарилах тухай баталгаатай шийдвэр хавсаргагдаагүй. |
| *10.* | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | Бэрх хотын захиргааны барилгын урд талбайд уурхайчин гэр бүл ба зөвлөлтийн инженерийн баримлыг хийлгэж, Бэрх хотын захирагчийн хамт нээлт хийж, хүлээлгэн өгөв. "Бэрх Уул" ХК-ийн төв оффисын урд талбайд хүндэтгэлийн гэрийн урд талбайд чулуу суулган засаж өөрчлөв. "Бэрх хотын уугах хаалганы ойролцоо тохижилтын ажлыг хийв. Уугалтын хаалганы ойр орчимд нарны зайн тэжээлийн үүсгүүрт гэрэлтүүлэг хийсэн. "Бэрх Уул" ХК-ийн төв оффист босоо душ, суултуур, угаалтуур суурилуулан ариун цэврийн өрөөг шинэчлэн засварлаж тохижуулав. Хэнтий аймгийн Батноров суманд зохион байгуулагдсан марафон тэмцээний үеэр 2000 ширхэг цэвэр ус хандивлаж, сумын иргэдийн спортын тэцээнийг дэмжиж буйгаа илэрхийлэв. "Чандганы уурхайн хэсэгт техник шинэчлэлт хийсэн. Чандганы хэсэгт ажилчидын хүнсний ногоо тариалж өөрсдийн хэрэгцээг хангасан. Малын тэжээлд цагас, ажилчдын амжиргаанд чацарганы мод тариж нутагшуулж байгын арчилгаа усалгаа хийж байна. Хэнтий аймгийн мөрөн суманд нийтийн бие засах газар хийж байрлуулж өгсөн. Чандганд шинээр ХХАБ өрөө байгуулан тохижуулсан. Аюулгүй байдал, харуул хамгаалалтандаа анхааран бүрэн камержуулсан Нийгмийн хариуцлагын хүрээнд Тэмдэглэлт баярын ажилчид байгалиа нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцож, ойн сан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр Мөрөн сумын Чандгана багт байрлах Чандганы уурхайд мод тарих ажилд идэвхитэй оролцож байна. өдрүүд, шуурхай үйл гэнэтийн явдлыг тохиолдуулан Бэрх хотын захирагчийн албатай хамтран ажиллах, арга хэмжээнүүдийг зохион байгуулах, хандив зэргээр олон нийтийн оролцоог ханган ажиллав. "Бэрх Уул" ХК-ын Нийгмийн хариуцлагын хүрээнд Ардын хувьсгалын 106 жилийн ой, Батноров сумын үндэсний их баяр наадмын үйл ажиллагаанд хандив өгөв. 2025.07.11 Үндэсний сурын харвааны нээлттэй тэмцээнийг "Бэрх уул" ХК-ийн нэрэмжит болгон ивээн тэтгэж, цаашид уламжлал болгон зохион байгуулахаар боллоо. Ахмадын баярын үеэр азын сугалаа баярлуулав. явуулж, ахмадуудаа Ахмадын баяраар Бэрх-Уул ХК-ийн 105 ахмад настанд 100'000 төгрөг өгч, хүндэтгэл үзүүлэв. Эх үрсийн баяраар бяцхан үрсдээ бэлэг бэлдэж баярлуулах үйл ажиллагаа уламжлал болсон байна. |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Амарсайхан Даваажав

Албан тушаал: "Бэрх Уул" ХК-ийн

гүйцэтгэх захирал

Гарын үсэг: ……

*(Тамга тэмдэг)*

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Баярхүү Оюунчимэг

Албан тушаал: Хүний нөөцийн

мэргэжилтэн

Гарын үсэг: ……